

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА, САНГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 122/58

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125, 145/124 дугаар хамтарсан тушаалд дараах агуулга бүхий 2 дугаар хавсралт тус тус нэмсүгэй:

1/144/125 дугаар тушаалд:

Зээл, факторингийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа хийгдэж байгаа буюу 120 хоног хүртэл хугацаа хэтэрсэн	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 121-180 хүртэл хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 181-270 хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 271-360 хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 361-ээс дээш хоног хэтэрсэн.

2/ 145/124 дүгээр тушаалд:

Зээл, санхүүгийн түрээсийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
---------	--------	------------------	------------	-------------	-----

Хугацааны үзүүлэлт	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа хийгдэж байгаа буюу 120 хоног хүртэл хугацаа хэтэрсэн	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 121-180 хүртэл хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 181-270 хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 271-360 хоног хэтэрсэн.	Үндсэн төлбөр, хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 361-ээс дээш хоног хэтэрсэн.
--------------------	--	---	--	--	---

2.Энэ тушаалын 1 дэх заалтад заасан нэмэлт хавсралтыг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар 31-ний өдөр хүртэлх хугацаанд дагаж мөрдөхөөр тогтоосугай.

3.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125, 145/124 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.4 дэх заалт, “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.4 дэх заалт, тэдгээрийн хавсралтын “Зээл, факторингийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт”, “Зээл, санхүүгийн түрээсийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт”-ийн үйлчлэлийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар 31-ний өдөр хүртэлх хугацаанд түр зогсоосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар /Ц.Зоригтбат/-т тус тус даалгасугай.

